



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 116

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасч,
сэлбэг материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.3 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг.Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 50,000,000 /тавин сая/ төгрөгийн балансын үнэтэй, 40,000,000 /дөчин сая/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ДУА 00-19 улсын дугаартай TOYOTA land Cruiser 200 маркийн автомашин, 19,990,000 /арван есөн сая есөн зуун ерэн мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй ДУА 66-03 улсын дугаартай УАЗ 220692-033 маркийн пургон автомашиныг тус тус акталж, сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах, акталснаас гарах сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр.Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын
20-ны өдрийн 16 тогтоолын хавсралт



ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АКТЛАХ ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ

Тээврийн хэрэгсэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэр-лэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			сери	дугаар			арлын дугаар	моторын эзлэхүүн				
1	Суудал	TOYOTA land Cruiser 200	ДУА	00-19	2008	2019.03.20	JTMCU09J804011270			50,000,000.00	10,000,000.00	40,000,000
2	Суудал	УАЗ 220692-033	ДУА	66-03	2011	2012.02.28	374100B0466419	D2890	98481	19,990,000	19,990,000	-